

МОНГОЛ УЛС: АЙМГУУДЫН ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН ТАЙЛАН 2020

(2019 оны статистик мэдээлэл ашиглав)

www.aimagindex.mn

Энэхүү судалгааны тайланг Конрад-Аденауэр-Сангийн санхүүжилтээр хэвлэв.



ННА 65
ДАА 330
М-692

АЙМГУУДЫН ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН ТАЙЛАН

УЛААНБААТАР ХОТ
2020

ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО, ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН СУДАЛГААНЫ ТӨВ

Сан бизнес центр 9-р давхар,
Ерөнхий сайд Амарын гудамж 29,
Сүхбаатар дүүрэг,
Улаанбаатар хот,
Монгол Улс

Утас: 976-11-321927
Факс: 976-11-321926

Аймгуудын өрсөлдөх чадварын тайлангийн цахим хуудас: www.aimagindex.mn

Цахим шуудан: info@ecrc.mn

Цахим хуудас: www.ecrc.mn
www.nogoonhutuch.mn

Фейсбүүк хуудас: <https://www.facebook.com/Ursulduhchadvar>

Твиттер хуудас: <https://twitter.com/ursulduhchadvar>

ISBN 978-9919-24-103-2

© Зохиогчийн эрх хуулиар хамгаалагдсан. Бүтээлийг зөвшөөрөлгүйгээр бүтнээр болон хэсэгчлэн хувилах, нийтлэх, ямар нэг хадгалах системд оруулахыг хориглоно.

ӨМНӨХ ҮГ



Эрхэм Таны амар амгаланг айлтгая!

Дэлхий дахинд болон Монгол Улсад 2020 онд олон чухал үйл явдал болж өнгөрлөө. Хүн төрөлхтнийг сорьсон ковид-19 цар тахал дэлхий даяар тархаж, түүний эсрэг вакцин бүтээхийн төлөө шинжлэх ухааны төвүүд цаг хугацаатай уралдах зуур Монгол Улсад УИХ-ын болон Орон нутгийн ээлжит сонгууль болж төр засаг, орон нутгийн захиргаа ирэх 4 жилд улс, аймаг хотоо удирдах, хөгжлийн бодлогоо хэрэгжүүлэх удирдагчдаа сонголоо.

Эдгээртэй зэрэгцээд Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төвийн 10 жилийн ой тохиосныг дуулгахад таатай байна. Иргэн П.Цагаан миний бие, Ц.Болдбаатар нарын хэсэг нөхдийн хамт, Монголын бизнесийн томоохон байгууллагууд болох Ньюком, Мобиком, Худалдаа хөгжлийн банк, МАК, MCS-ийн дэмжлэгтэйгээр 2010 онд тус төвийг үүсгэн байгуулж байсан бол өдгөө дэлхийн өрсөлдөх чадварын тайланг боловсруулах ажилд хамтран оролцоод зогсохгүй гадаадын зарим орны өрсөлдөх чадварын судалгаа хийхэд дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. Өнгөрсөн 10 жилийн хугацаанд манай төв Олон улсын удирдлагын хөгжлийн хүрээлэнгийн дэргэдэх Дэлхийн өрсөлдөх чадварын судалгааны төв, Дэлхийн өрсөлдөх чадварын зөвлөхүүдийн холбоо, Ногоон эдийн засгийн холбоонд нэгдэв. Дэлхийн ихэнх улс оронд эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааг төрийн дэмжлэгтэйгээр явуулдаг бол Монгол Улсын хувьд энэ ажлыг сүүлийн 10 жилд манай төв сайн санаат хувь хүмүүс, олон улсын байгууллага, үндэсний бизнес эрхлэгч хувийн хэвшлийн байгууллагуудын дэмжлэгтэйгээр дангаараа гүйцэтгэж ирлээ.

Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төвөөс эрхлэн гаргадаг Монгол Улсын өрсөлдөх чадварын тайлан, Аймгуудын өрсөлдөх чадварын тайлан, Дүүргүүдийн өрсөлдөх чадварын тайлангаас Монгол Улсын Засгийн газар, аймаг, хотын удирдлагууд үйл ажиллагааныхаа үр дүнг, хөгжлийн сайн болон саар үзүүлэлтээ тольдон хардаг боллоо. Энэ бол Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төвийн судлаачдын 10 жилийн ажлын үр дүн.

2020 оны хувьд Аймгуудын өрсөлдөх чадварын судалгааг ҮСХ-оос 2020 оны 7-р сард танилцуулсан “Монгол Улсын статистикийн эмхэтгэл 2019” буюу цар тахлаас үүдэлтэй хөл хорионоос өмнөх үеийн мэдээлэл, 21 аймгийн бизнес эрхлэгчдээс 2020 оны 9-р сард авсан санал асуулга буюу цар тахал, хөл хорионы үеийн мэдээллийг ашиглан гүйцэтгэснийг дурьдах нь зүйтэй болов уу.

Энэ жилийн онцлох үр дүнгээс дурьдвал:

- Орхон аймгийн ерөнхий үнэлгээ 1-т, эдийн засгийн тамир тэнхээ 3-т эрэмбэлэгдэж, өнгөрсөн оны үнэлгээний эрэмбэд өөрчлөлт ороогүй;
- Дорноговь аймаг ерөнхий үнэлгээгээр 2-т (өмнөх жил 3-т байсан), эдийн засгийн тамир тэнхээгээр 2-т эрэмбэлэгдэж эрэмбээ ахиулсан боловч нийт оноо нь 5-аар буурсан;

- Дархан-Уул аймаг ерөнхий үнэлгээгээр 3-т эрэмбэлэгдэж (өмнөх жил 4-т эрэмбэлэгдэж байсан) эрэмбээ ахиулсан ч эдийн засгийн тамир тэнхээгээр 10-т орж Бизнесийн үр ашиг, Дэд бүтэц бүлгийн оноо нь 2-оор тус тус буурсан;
- Өмнөговь аймаг ерөнхий үнэлгээгээр 4-т эрэмбэлэгдэж өмнөх оноос 2 байраар ухарсан ч эдийн засгийн тамир тэнхээгээр 1-т эрэмбэлэгдсэн хэвээр байна. Засаглалын үр ашиг бүлгийн оноо ихээхэн буурчээ;
- Төв аймаг сүүлийн нэг жилд хамгийн ихээр оноо нь буурч өмнөх онд 12-т эрэмбэлэгдэж байсан бол 2020 онд 15-т орж ирлээ. Нийт 23 оноо буурсан нь анхаарал татаж байна;
- Ховд аймаг 10 оноогоор, Увс аймаг 9 оноогоор өрсөлдөх чадварын үзүүлэлтээ ахиулж чадсан нь өнгөрөгч 1 жилд хамгийн өсөлттэй үзүүлэлттэй аймгууд боллоо;
- 21 аймгаас Булган [21], Говь-Алтай [20], Баянхонгор [19] аймгууд сүүлд эрэмбэлэгдлээ. Эдгээр 3 аймгийн хувьд Засаглалын үр ашиг үзүүлэлт хамгийн муу хэвээр байна.

Эдийн засаг хүндрэлтэй, цар тахлын нэмэлт ачаалалтай байгаа ийм үед аймаг орон нутгаа хөгжүүлэхэд Аймгуудын өрсөлдөх чадварын судалгааны тайлан хэрэгцээтэй гарын авлага болох нь дамжиггүй. Судалгааны тайланг хэвлэмэл болон цахим хэлбэрээр танилцуулахаас гадна, судалгаа хийгдэж эхэлсэн 2012 оноос хойших жил бүрийн Аймгуудын өрсөлдөх чадварын ерөнхий болон үндсэн бүлгийн индекс, шалгуур үзүүлэлт нэг бүрийн мэдээллийг www.aimagindex.mn вебсайтаас харах боломжтой.

Өрсөлдөх чадварын судалгааны тайлан бол уралдаан биш, харин эрх бүхий байгууллагаас явуулсан бодлого, үйл ажиллагааны бодит үр дүнгийн үзүүлэлт гэдгийг ойлгох хэрэгтэй. Тайлангаас аймгийнхаа хөгжлийн ямар үзүүлэлт нь хангалттай байгааг, ямар нь хангалтгүй байгааг олж харах боломжтой. Хүний биеэр жишвэл шинжилгээний дүнд үндэслэж бичсэн эмчийн онош гэж ойлгож болно. Бодит байдал, оношоо мэдээд зөв эмчилгээ буюу үйл ажиллагаа явуулбал аймаг орон нутаг хөгжлөө өөд нь татах боломжтой. Бодит байдал, оношоо мэдэхгүйгээр эмчилгээ хийх гэж оролдвол үргүй зардал, оновчгүй хөрөнгө оруулалт, хоосон хөдөлмөр болно.

Энэ дашрамд, манай тайланг гаргахад бодитоор дэмжиж ирсэн Азийн сан, Конрад-Аденауэр-Сан, Германы Олон Улсын хамтын ажиллагааны нийгэмлэг болон манай үйл ажиллагааг байнга дэмжин ажилладаг байгууллага, хувь хүмүүст гүн талархал илэрхийлье.

Хэмжиж чадвал хянаж чадна

Хянаж чадвал удирдаж чадна

Удирдаж чадвал хөгжүүлж болно.

Хүндэтгэсэн,



Пунцагийн ЦАГААН

УЗ-ийн дарга, доктор (Ph.D)

СУДАЛГААНЫ БАГ

Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв

Удирдах зөвлөлийн дарга П.Цагаан

Ерөнхий захирал Б.Лакшми

Дэд захирал И.Одончимэг

Судлаач Б.Мөнгөнжигүүр

Судлаач Э.Тунгалаг

Судлаач Х.Есөнчулуу

Судлаач П.Мөнхшүр

ДЭМЖИГЧ БАЙГУУЛЛАГУУД



The Asia Foundation

Азийн Сан



Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим
Орон нутаг дахь салбар танхимууд

СТАТИСТИК МЭДЭЭЛЛИЙН ЭХ СУРВАЛЖ



Үндэсний статистикийн хороо



Монголбанк

ГАРЧИГ

Товчилсон нэрсийн жагсаалт	9
“УЧРЫГ НЬ ОЛЖ, ХУЖРЫГ НЬ ТУНГААХ” ЦАГ	10
СУДАЛГААНЫ ЗАРЧИМ, АРГАЧЛАЛ.....	13
АЙМГУУДЫН ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН ҮНЭЛГЭЭ	19
Өрсөлдөх чадварын хүчин зүйлс.....	20
Өрсөлдөх чадварын ерөнхий үнэлгээ 2020.....	21
Өрсөлдөх чадварын амжилтын хүрээ.....	27
АЙМГУУДЫН ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН ТӨЛӨВ БАЙДАЛ.....	31
СТАТИСТИК ХҮСНЭГТҮҮД.....	117
1. Эдийн засгийн тамир тэнхээ.....	119
2. Засаглалын үр ашиг.....	131
3. Бизнесийн үр ашиг.....	143
4. Дэд бүтэц.....	155
БАЙГАЛЬ ОРЧНЫ ЭМЗЭГ БАЙДЛЫН ОЛОН ХУВЬСАГЧТАЙ ХЭМЖҮҮР ...	177
ХАВСРАЛТ.....	187
Өрсөлдөх чадвар судлалын тухай ерөнхий ойлголт.....	188
Мэдээллийн эх сурвалж, тайлбар.....	190

Аймгуудын өрсөлдөх чадварын төлөв байдал

АРХАНГАЙ	32
БАЯН-ӨЛГИЙ	36
БАЯНХОНГОР	40
БУЛГАН	44
ГОВЬ-АЛТАЙ	48
ГОВЬСҮМБЭР	52
ДАРХАН-УУЛ.....	56
ДОРНОГОВЬ	60
ДОРНОД	64
ДҮНДГОВЬ	68
ЗАВХАН	72
ОРХОН	76
ӨВӨРХАНГАЙ	80
ӨМНӨГОВЬ	84
СҮХБААТАР	88
СЭЛЭНГЭ	92
ТӨВ	96
УВС	100
ХОВД	104
ХӨВСГӨЛ.....	108
ХЭНТИЙ	112

Товчилсон нэрсийн жагсаалт

ААН	Аж ахуйн нэгж
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ДЦС	Дулааны цахилгаан станц
ЖДҮ	Жижиг, дунд үйлдвэр
МБ	Монголбанк
МҮХАҮТ	Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ЭЗБӨЧСТ	Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв

"УЧРЫГ НЬ ОЛЖ, ХУЖРЫГ НЬ ТУНГААХ" ЦАГ

Аймгуудын өрсөлдөх чадварын тайланд тухайн аймгийн өнөөгийн хөгжлийн түвшин, давуу болон сул тал, асуудал болон боломжийг ихэвчлэн тоон утгаар илэрхийлдэг ч аймгуудын өрсөлдөх чадварын төлөв байдал хэсэгт аймаг тус бүрийн тулгарч буй бэрхшээлийг нэрлэн бичсэн байдаг нь дутагдалдаа анхааран өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэхэд тун чухал мэдээлэл юм. Энэхүү тулгарч буй бэрхшээлийг аймаг бүрийн бизнесийн байгууллагын удирдах албан тушаалын ажилтнуудаас авсан санал асуулга дах "Аймгийн хөгжил, өрсөлдөх чадвар, бизнесийн орчныг сайжруулахад тулгамдаж буй асуудал, төрийн зүгээс анхаарвал зохих 5 гол үйл ажиллагааг нэрлэнэ үү?" гэх нээлттэй асуултаар тодруулдаг тул эргэлзээгүй анхаарахуйц бодит асуудал гэдэгт итгэлтэй байна.

Тасралтгүй 9 жил боловсруулагдаж буй Аймгуудын өрсөлдөх чадварын тайланд өнгөрсөн хугацаанд дараах асуудлууд хамгийн олон удаа нэрлэгдсэн байна. Үүнд:


Хүснэгт 1. Асуудал /21 аймаг, 9 жил/

Бизнес, үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих /төр хувийн хэвшлийн түншлэл, уян хатан татварын бодлого, шударга өрсөлдөөн бүхий орчин/
Төрийн үйлчилгээг сайжруулах /хүнд суртал, байгууллага хоорондын уялдаа, боловсон хүчний чанар, шуурхай ажиллагаа/
Дэд бүтцийн хөгжил /авто замын чанар, хот төлөвлөлт, эрчим хүч, дулааны шугам сүлжээ/
Ажлын байр нэмэгдүүлэх

Дээрх асуудлууд баруун, зүүн, говийн, төвийн, хангайн бүс нэг бүрт хамгийн олон удаа мөн адил нэрлэгдсэн. Үүнээс үзэхэд аймгийн хөгжилд тулгамдаж буй голлох асуудлууд бүсээс үл хамааран ижил байна.

Энэ жилийн судалгаанд дараах асуудлууд хамгийн олон аймагт гол асуудлаар нэрлэгдлээ. /График 1/ Үүнд:

График 1. Тухайн асуудал нэрлэгдсэн аймгийн тоо



Асуудлуудын зарим нь шийдвэрлэгдсэнээр аймгийн хөгжилд тулгамдаж буй гол 5 асуудалд жил бүр өөрчлөлт ордог ч улиран нэрлэгддэг буюу тухайн аймгийн хөгжлөөс хойш татсаар буй асуудлууд байна.

График 2. Тухайн асуудал нэрлэгдсэн жилийн тоо



- Бизнес, үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих /төр хувийн хэвшлийн түншлэл, шударга өрсөлдөөн бүхий орчин/
- Төрийн үйлчилгээг сайжруулах /хүнд суртал, байгууллага хоорондын уялдаа, боловсон хүчний чанар, шуурхай ажиллагаа/
- Уян хатан татварын бодлого
- Авто замын чанар сайжруулах
- Ажлын байр нэмэгдүүлэх, Ил тод, шударга тендер явуулах
- Банкны зээлийн нөхцлийг сайжруулах /хүү бууруулах, хугацаа уртасгах, бага барьцаа/


Шалгуур үзүүлэлт бүрийн утга, ерөнхий болон үндсэн бүлгийн индекс оноо нь тоогоор илэрхийлэгддэг тул өөрчлөлт, ахиц, уруудалтаа үнэлэн хэрэглэхэд хялбар байдаг. Гэвч индекс тооцоход шууд оролцдоггүй нэрлэн бичсэн аймаг бүрийн тулгамдсан асуудлыг онцгой анхаарвал зохилтой.

Асуудал үргэлж оршдог. Гэхдээ асуудлыг шийдвэрлэвэл давуу боломж нээгддэг.

2020 оны тайлангийн үр дүнгээс:


Энэ жилийн Аймгуудын өрсөлдөх чадварын ерөнхий онооны дундаж 63 болж өнгөрсөн жилээс 5 оноогоор буурлаа.

График 3. Аймгуудын өрсөлдөх чадварын ерөнхий онооны дундаж



Өрсөлдөх чадварын үндсэн 4 бүлгээс эдийн засгийн тамир тэнхээ, бизнесийн үр ашиг бүлгийн дундаж оноо өссөн бол засаглалын үр ашиг, дэд бүтэц бүлгийн дундаж оноо буурсан байна.


График 4. Өрсөлдөх чадварын үндсэн 4 бүлгийн оноо өөрчлөгдсөн аймгийн тоо



Өрсөлдөх чадварын ерөнхий үнэлгээгээр Орхон, Дорноговь, Дархан-Уул, Өмнөговь аймгууд тэргүүлсэн нь өнгөрсөн онд эхний 4-т эрэмбэлэгдсэн аймгууд билээ. Гэхдээ Өмнөговь аймаг 2 эрэмбэ ухарч 4-рт, Дорноговь, Дархан-Уул аймгууд тус бүр 1 эрэмбэ урагшилж 2, 3-рт эрэмбэлэгдсэн бол Орхон аймаг 1-рт эрэмбэлэгдсэн хэвээр байна. Харин сүүлийн байруудад Баянхонгор, Говь-Алтай, Булган аймгууд эрэмбэлэгдлээ.

Энэ жилийн тайлангаас харахад 21 аймгаас 7 аймгийн өрсөлдөх чадварын ерөнхий оноо өнгөрсөн жилээс өссөн бол 13 аймгийн оноо буурч, 1 аймгийн оноо өөрчлөгдөөгүй байна.

График 5. Өрсөлдөх чадварын ерөнхий оноо хамгийн их өөрчлөгдсөн аймгууд



Баруун бүсийн Ховд, Увс аймгууд өрсөлдөх чадварын оноогоо хамгийн ихээр ахиулсан бол тус бүсийн Говь-Алтай, Завхан аймгууд болон Төв аймгийн оноо хамгийн их буурав. Ховд, Увс аймгуудын өрсөлдөх чадвар сайжрахад бизнесийн үр ашиг, дэд бүтэц сайжирсан нь илүүтэйгээр нөлөөлөв. Завхан аймгийн дэд бүтэц, хөдөлмөрийн зах зээлийн үзүүлэлтүүд, Төв аймгийн засаглал, технологийн дэд бүтцийн үзүүлэлтүүд, Говь-Алтай аймгийн засаглал, эдийн засгийн үзүүлэлтүүд буурсан нь өрсөлдөх чадварын оноо буурахад түлхүү нөлөөлжээ.

Хуулийн шинэчилсэн найруулга

2020 оны 12-р сарын 24-нд Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль (шинэчилсэн найруулга) батлагдсан. Энэ хуулиар олон жил ярьсан орон нутагт эрх мэдлийг нь шилжүүлсэн. Эрх мэдэл гэдэгт төсөв, өмч, боловсон хүчин зэрэг орж байгаа бөгөөд 2022 оны 1-р сарын 1-ээс хэрэгжиж эхлэхээр байна.

Үүнийг дагаад өөр олон хуулиудад өөрчлөлт орно. Эдгээр өөрчлөлтүүд нь орон нутагтаа ард иргэддээ хүртээмжтэй өсөлтийг бий болгоно гэж найдаж байна. Эрх мэдэл нэмэгдэж байгаа хэдий ч хариуцлага бас нэмэгдэж байгаа гэж ойлгох хэрэгтэй. Иймд энэхүү боломжийг ашиглаад бизнес эрхлэгчдийгээ дэмжих оновчтой бодлого гаргаж хэрэгжүүлээсэй.

СУДАЛГААНЫ ЗАРЧИМ, АРГАЧЛАЛ

Судалгааны зорилго, ач холбогдол

Аймгуудын өрсөлдөх чадварын судалгааны зорилго нь Монгол Улсын 21 аймгийн хөгжлийн өнөөгийн түвшинг харьцуулан үнэлэх, аймгуудын өрсөлдөх чадварыг цогц байдлаар тодорхойлоход оршино. Судалгаагаар аймаг бүрийн хөгжлийн давуу ба сул талыг тодорхойлж, өрсөлдөх чадварын боломж, чадавхыг үнэлэн тогтвортой, урт хугацааны хөгжлийн бодлого боловсруулахад ашиглахуйц өргөн хүрээний мэдээллийн сан бүрдүүлнэ.

Аймгуудын өрсөлдөх чадварыг хооронд нь харьцуулж, өрсөлдөх чадварын чиг хандлагыг тодорхойлохоос гадна тухайн аймгийн өрсөлдөх чадварыг хойш татаж буй эсвэл дээшлүүлж буй үзүүлэлтүүдийг тогтоож, өрсөлдөх чадварын давуу, сул талыг үнэлэх боломж олгож буй нь энэхүү судалгааны давуу тал юм. Ингэснээр аль аймаг яагаад өрсөлдөх чадварын хувьд бусдаас сайн эсвэл сул байгааг ойлгож мэдэх, тухайн аймаг давуу талаа хэрхэн ашиглаж болох хөгжлийг хойш татаж буй сул талаа хэрхэн шийдвэрлэх шийдлийг олоход чухал эх үүсвэр болох юм.

Дашрамд дурьдахад, уг судалгаа нь аймгуудын өрсөлдөх чадварыг хооронд нь харьцуулан судалж буй тул өрсөлдөх чадвараараа тэргүүлсэн аймгуудыг өрсөлдөх чадвар хангалттай сайн гэж ойлгож болохгүй. Харин тэдгээр аймаг өрсөлдөх чадвараараа бусдаас харьцангуй илүү байгаа ч өөрийн өрсөлдөх чадварын сул

үзүүлэлтүүдийг сайжруулах, давуу талаа ашиглан илүү хурдтай хөгжих хэрэгтэйг харуулна. Үүний адилаар өрсөлдөх чадвараар сүүл мушгисан аймгуудын хувьд ч тухайн аймгууд өрсөлдөх чадвар муутай гэхээс илүү бусад аймагтай харьцуулахад өрсөлдөх чадвараар сул байна хэмээн ойлгож, өрсөлдөх чадварыг ямар үзүүлэлтүүд хойш татаж буйг тодорхойлж, тэдгээрийг сайжруулахад анхаарах нь зүйтэй.

Аймгуудын өрсөлдөх чадварын тайлан нь бодлого боловсруулагчдын хувьд аймгуудын өнөөгийн хөгжлийн түвшин, нөхцөл байдлыг бодитоор харж орон нутгийг хөгжүүлэхэд чиглэсэн илүү үр ашиг бүхий шийдвэр гаргахад тус болохуйц мэдээллийн эх үүсвэр, гарын авлага байх юм. Түүнчлэн аймгийн удирдлагууд өөрийн бодлого шийдвэрүүдийн хэрэгжилтийн үр дүнг үнэлэх бусад аймагтай харьцуулах, туршлага судлах боломжтой юм. Мөн ажил хэрэгч хүмүүс бизнесийн болон хөрөнгө оруулалтын аливаа шийдвэр гаргахдаа орон нутгийн талаарх найдвартай бөгөөд цогц мэдээллийг энэхүү тайлангаас авч болох юм.

Мэдээллийн санг бүрдүүлэх ажлын хүрээнд www.aimagindex.mn сайтыг 2015 онд ашиглалтад оруулсан бөгөөд бүх жилүүдийн аймгуудын өрсөлдөх чадварын үзүүлэлтүүдийг харж болох ба өмнөх онуудтай харьцуулах боломжтой юм.

Аргачлал

1. Аймгуудын өрсөлдөх чадварын эрэмбийг тооцохдоо 4 үндсэн бүлэгт тулгуурласан.
 - Эдийн засгийн тамир тэнхээ
 - Засаглалын үр ашиг
 - Бизнесийн үр ашиг
 - Дэд бүтэц
2. Үндсэн бүлэг тус бүр 4 дэд бүлгүүдэд хуваагдах ба нийт 16 дэд бүлгээс бүрдэнэ.
3. Эдгээр 16 дэд бүлэг нь нийт 176 үзүүлэлтээс бүрдэнэ.
4. 176 үзүүлэлтийн 142 үзүүлэлтээр өрсөлдөх чадварын индексийг тооцон эрэмбэлсэн. Эдгээр 142 үзүүлэлтийн 68 нь статистик мэдээлэл, 74 нь санал асуулгаас бүрддэг.
5. Дэд бүлэг доторх үзүүлэлтийн тоо ялгаатай байх бөгөөд судалгааны үр дүнг бодитой, тэнцвэртэй байлгах үүднээс дэд бүлэг бүрийн эзлэх жинг дотроо хэдэн үзүүлэлттэйгээс үл хамааран тэнцүү ($16 \times 6.25\% = 100\%$) хэмжээтэй сонгосон.
6. 16 дэд бүлгээр тооцсон аймгуудын дундаж стандартчилсан үнэлгээнд суурилан 16 бүлгийн өрсөлдөх чадварын индексийг аймаг бүрээр дараах ерөнхий томъёогоор тооцоолно.

$$I = \frac{STD(x) - STD_{min}(x)}{STD_{max}(x) - STD_{min}(x)}$$

Энд:

I – Өрсөлдөх чадварын индекс

$STD(x)$ – Шалгуур үзүүлэлтийн стандарт үнэлгээ



$STD_{min}(x)$ - Шалгуур үзүүлэлтийн стандарт үнэлгээний хамгийн бага утга

$STD_{max}(x)$ - Шалгуур үзүүлэлтийн стандарт үнэлгээний хамгийн их утга

Аймгуудын өрсөлдөх чадварыг хэмжих үзүүлэлтүүд

Үндсэн хүчин зүйлс	Эдийн засгийн тамир тэнхээ	Засаглалын үр ашиг	Бизнесийн үр ашиг	Дэд бүтэц
Дэд хүчин зүйлс	<ul style="list-style-type: none"> • Эдийн засаг • Эдийн засгийн салбарууд • Хүн амын амьжиргааны түвшин • Хөдөлмөр эрхлэлт 	<ul style="list-style-type: none"> • Аймгийн төсөв • Институцийн тогтолцоо • Бизнесийн эрхзүй • Нийгмийн тогтолцоо 	<ul style="list-style-type: none"> • Бизнесийн орчин • Хөдөлмөрийн зах зээл, бүтээмж • Санхүү • Менежментийн хэвшил 	<ul style="list-style-type: none"> • Үндсэн дэд бүтэц • Технологийн дэд бүтэц • Боловсрол, соёл • Эрүүл мэнд, хүрээлэн буй орчин

Эрэмбэ тооцох арга



Аймгуудын өрсөлдөх чадварын тайланг хэрхэн ашиглах вэ?

Аймгуудын өрсөлдөх чадварын үнэлгээг дараах ерөнхий хэсгүүдээс харах боломжтой. Үүнд:

1. Аймгуудын өрсөлдөх чадварын үнэлгээ (19-30 хуудас)

Аймгуудын өрсөлдөх чадварын үнэлгээ нь 21 аймгийн нэгтгэсэн эрэмбээс тодорхой харагдана. Аймгууд өрсөлдөх чадвар хамгийн сайтаагаасаа эхлэн эрэмбэлэгдэнэ.

Өрсөлдөх чадварын ерөнхий ба үндсэн хүчин зүйлсийн эрэмбэ

Өрсөлдөх чадварын ерөнхий үнэлгээнээс гадна өрсөлдөх чадварын үндсэн хүчин зүйлс болох эдийн засгийн тамир тэнхээ, засаглалын үр ашиг, бизнесийн үр ашиг, дэд бүтэц тус бүрээр өрсөлдөх чадварын үнэлгээг харж болно.

Өрсөлдөх чадварын дэд хүчин зүйлсийн эрэмбэ

Өрсөлдөх чадварын үндсэн хүчин зүйл бүрийн 4 дэд хүчин зүйл буюу нийт 16 дэд хүчин зүйлийн эрэмбийг энэ хэсэгт багтаасан. Дэд бүлгүүдийн эрэмбэ нь тухайн үндсэн бүлэг бүрийн эрэмбийг илүү тодруулан нарийвчлан харуулах юм.

Өрсөлдөх чадварын амжилтын хүрээ

Энэ хэсэгт аймаг бүрийн өрсөлдөх чадварын үндсэн 4 бүлэг хүчин зүйлийн үнэлгээг 21 аймгийн дундаж үзүүлэлттэй харьцуулан харуулна. Торон графикайн тусламжтайгаар тухайн аймаг ямар үзүүлэлтээр илт давуу болон сул талтай болохыг харах боломжтой.

2. Аймгуудын өрсөлдөх чадварын төлөв байдал (31-116 хуудас)

Энэ бүлэгт аймаг тус бүрийн эдийн засгийн ерөнхий байдал, өрсөлдөх чадварын амжилтын хүрээ, өрсөлдөх чадварын дэд хүчин зүйлсийн эрэмбэ тухайн аймгийн хөгжилд тулгарч буй саад бэрхшээл, шийдвэрлэх асуудлыг нэгтгэн харуулсан.

Түүнчлэн өрсөлдөх чадварын 4 үндсэн хүчин зүйл болох эдийн засгийн тамир тэнхээ, засаглалын үр ашиг, бизнесийн үр ашиг, дэд бүтэц тус бүрийн 10 сул болон 10 давуу талыг тодотгон үзүүлсэн. Аймгийн эдийн засгийн орчин, ирээдүйн хөгжилд ач холбогдолтой өрсөлдөх чадварын давуу болон сул талыг тогтоох нь тун чухал. Учир нь тухайн аймаг өөрийн өрсөлдөх чадварын хамгийн сайн, давуу талдаа тулгуурлан хөгжиж, баялгийг бүтээдэг. Түүнчлэн давуу талаа ашиглахын зэрэгцээ сул талаа хянаж, сайжруулах нь аймгуудын өрсөлдөх чадварыг сайжруулахад түлхэц болно.


Мөн аймгуудын өрсөлдөх чадварыг хооронд нь харьцуулахаас гадна Өрсөлдөх чадварын хувьсал хэсгээс тухайн аймгийн өрсөлдөх чадварын үзүүлэлтийг өмнөх жилтэй нь харьцуулсан 25 өсөлт, 25 бууралтыг харах боломжтой.

3. Статистик хүснэгт (117-176 хуудас)

Энэ хэсэгт өрсөлдөх чадварын хүчин зүйлсийг тодорхойлж буй шалгуур үзүүлэлтийг дэлгэрэнгүй багтаасан. Эндээс нийт 176 шалгуур үзүүлэлт бүрийн эрэмбэ, мэдээллийг харж болно.

АЙМГУУДЫН ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН ҮНЭЛГЭЭ

Өрсөлдөх чадварын хүчин зүйлс



Өрсөлдөх чадварын ерөнхий үнэлгээ 2020

